

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам /Х.Булгантуяа/-нд үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 60 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

Гарын үсэг

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛСНӨӨР ТООЦОХ ЖУРАМ

НЭГ.Нийтлэг үндэслэл

1.1.Даатгуулагчийн Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 23 дугаар зүйлд заасан хугацааг нийгмийн даатгалын шимтгэл (цаашид “шимтгэл” гэх) төлсөн хугацаанд оруулан тооцохтой холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

ХОЁР. Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох хугацааг тодорхойлох

2.1. Даатгуулагчийн шимтгэл төлснөөр тооцох хугацааг дор дурдсан баримт бичигт үндэслэн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцно. Үүнд:

2.1.1.ажилтны 1991 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хөдөлмөрийн гэрээгээр ажилласан хугацааг хөдөлмөрийн дэвтрийг, хөдөлмөрийн дэвтрийн бичилт засвартай, буруу, зөрүүтэй бичигдсэн, хуурамч эсхүл үрэгдүүлсэн, хуулбарласан тохиолдолд ажилд орсон, ажлаас чөлөөлсөн тухай архивын лавлагаа, архивын баримтаар нотлогдохгүй бол ажилласан жил сэргээн тогтоосон шүүхийн шийдвэрийг;

2.1.2.ажилтны төр, хувийн өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллага, хөдөө аж ахуйн нэгдэл, хоршоолол, шашны байгууллагад 1991 оны 7 дугаар сарын 1-нээс 1995 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хувийн хэвшлийн байгууллагад ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг хөдөлмөрийн дэвтрийг үндэслэн тооцно. Энэ тохиолдолд ажиллаж байсан байгууллага нь цалингийн сангаас 13.5 хувиар тэтгэврийн санд шимтгэл төлсөн тухай аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрын архивын лавлагааг;

2.1.3.иргэний 1995 оноос өмнө цэргийн жинхэнэ болон хугацаат цэргийн алба хаасан хугацааг тухайн цэргийн ангиас баталгаажуулсан цэргийн батлах (үнэмлэх)-ыг үндэслэн тооцох бөгөөд хэрэв засвартай, буруу, зөрүүтэй бичигдсэн тохиолдолд цэргийн байгууллагын архивын лавлагааг;

2.1.4.тэтгэврийн даатгалын шимтгэлийг 10-с доошгүй жил төлсөн, төрүүлсэн болон гурав хүртэл настайд нь үрчлэн авсан хүүхдээ зургаан нас хүртэл өсгөсөн эхийн төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэд бүрийн тоогоор нэг жил зургаан сараар тооцсон хугацааг хүүхдийн төрсний гэрчилгээний хуулбар, холбогдох лавлагааг;

2.1.5.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн цэргийн жинхэнэ алба хаасан нэг жилийг тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн нэг жил зургаан сараар тооцсон хугацааг цэргийн батлах (үнэмлэх)-ыг үндэслэн тооцох бөгөөд хэрэв засвартай, буруу, зөрүүтэй бичигдсэн тохиолдолд цэргийн байгууллагын архивын лавлагааг;

2.1.6.1995 оноос өмнө ажилласан хугацааг холбогдох хуулийн дагуу нөхөн тооцож баталгаажуулсан хугацааг нийгмийн даатгалын байгууллагаас олгосон “Баталгаажилтын хуудас”, холбогдох лавлагааг;

2.1.7.даатгуулагчийн Дипломат албаны тухай хуулийн дагуу цаг уурын хүнд нөхцөл бүхий улсад ажилласан нэг жилийг нэг жил зургаан сараар тооцсон хугацааг гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас дипломат албан тушаалд томилсон тушаал, нийгмийн даатгалын шимтгэл төлснийг нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-ын баталгаажуулсан 1995-2020 оны хоорондох нийгмийн даатгалын дэвтэр, түүнээс хойших хугацааг нийгмийн даатгалын цахим дэвтрийг.

ГУРАВ. Бусад

3.1.Энэхүү журмыг зөрчсөн хүн, баримтаар тогтоогдсон гэм буруутай хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---